

Олон улсын Театрын өдөр 2018 – Европ тив

Симон МакБурней, Нэгдсэн вант улс

Жүжигчин, зохиолч, Театр де Комплицити театрын үүсгэн байгуулагч ба тайзны найруулагч

Умард Ливи дэх Циренайсийн эргээс хагас милл орчмын зайд асар том чулуун халхавч бий. 80 метр өргөн, 20 метр өндөртэй. Нутгийн хэлээр үүнийг Хау Фтеах гэдэг. 1951 онд нүүрстөрөгчийн хагас задралын агаар тооцоолон 100,000 жилийн тэртээ хүмүүс хэнээс ч хамааралгүй тэнд амьдардаг байсныг нотлов. Эд өлгийн олдворууд дунд 40-70 мянган жилийн өмнөх хугацаанд хамаарах ясаар урласан лимбэ байлаа. Бяцхан хүү үүнийг сонсоод ааваасаа асууж гэнэ.

“Тэд хөгжимтэй байсан гэж үү”

Түүн рүү инээмсэглээд “Бүх хүмүүсийн адил” гэж хариулав.

Тэр америкт төрсөн эртний түүх судлаач, хамгийн анх Циренайсийн Хау Фтеахад археологийн малтлага хийсэн хүн байв.

Энэ жилийн олон улсын театрын өдөр би Европ тивийг төлөөлөн оролцож байгаадаа туйлын баяртай байна.

Надаас өмнөх төлөөлөгч болох агуу Артур Миллер 1963 онд дэлхий дахинд цөмийн дайны аюул заналхийлэн байсан тэр үед хэлэхдээ, “Дэндүү богино ба сул дорой гартай дипломат харилцаа, улс төрийн энэ цаг үед хүн төрөлхтнийг нэгтгэн барьж байдаг урт бөгөөд эмзэг нандин тэр гар нь урлаг байх ёстой юм” гэсэн байдаг.

Драм хэмээх энэ үг грек хэлний “дран” буюу “хийх, үйлдэх” гэсэн үгнээс гаралтай ... харин театр хэмээх үг нь грек хэлний “театрон”, шууд утга нь “харах газар” гэсэн үгээс гаралтай. Энэ газар нь бидний ямар нэгэн юмыг үзэж хардаг газар төдий бус бид үзээд, ойлгоод, ухаарч байдаг газар юм. 2400 жилийн өмнө залуу Поликлеит Эпидаурус хэмээх агуу том театрын загварыг зохиожээ. 14 мянган суудалтай дуу авиа гайхалтай сонсогддог энэ задгай театр бол гайхамшиг. Тайзны яг голд шүдэнз зурахад 14 мянган хүн бүгдээрээ тэрхүү чимээг сонсож чаддаг. Грекийн театруудын адил жүжигчдийг ширтэхийн сацуу тэдний цаана буй үзэсгэлэнт байгалийг ч бас харж ажиглаж болно. Энэ бол хэд хэдэн газар нэг дор ирчихээд байгаа хэрэг бус харин хүн ард, театр болон байгаль дэлхий нэгдэж, цаг үргэлж хамтдаа гэдгийг ухааруулж буй хэрэг. Жүжгийн өрнөл өнгөрсөн үеийн түүхийг өнөө цагт авчрахад та тайзны цаад руу өнгийн хараад ирээдүйд юу болохыг ойлгоно. Байгаль.

Лондох дахь Шексперийн Глоб театрын шинэчлэлийн хамгийн гайхамшигтай үзэгдэл мөн л таны юу харж чадаж байгаатай холбоотой. Энэ үзэгдэл бол гэрэлтэй холбоотой. Тайз болон үзэгчдийн танхим яг адил гэрэлтүүлэгтэй.

Жүжигчид, үзэгчид бие биенээ маш тод харж байдаг. Үргэлж. Хаашаа ч харсан таны эргэн тойронд хүмүүс л байна. Үүний үр дүн нь бидний агуу бүтээлүүд, жишээлбэл Гамлет эсвэл Макбет нар зүгээр нэг ганцаар эрэгцүүлэн тунгаах бүтээлүүд бус харин нийтээр хэлэлцэх сэдэв гэдгийг сануулж байдагт оршино.

Бид аливааг тод тодорхой харахад тун хэцүү цаг үед амьдарч байна. Бид эртний болоод эдүгээгийн түүхийн бүхий л үед урь өмнө байгаагүй ихээр зохиомол юмсаар хүрээлүүлэн амьдарч байна. Ямар ч 'баримтыг' шалгаж болно, ямар ч онигоо нэг мэдэхэд 'үнэн' мэт бидний анхаарлыг татах гэнэ. Гэхдээ биднийг цаг үргэлж нэг зохиол байнга хүрээлнэ. Тэр бол биднийг хагаралдуулагч. Үнэнээс холдуулагч. Биднийг нэг нэгнээс маань хөндийрүүлэгч. Ингээд л бид тус тусдаа салцгаачихаж. Хүмүүс өөр хоорондоо. Эрчүүд эмэгтэйчүүдээс. Хүмүүс байгалиас салан холдож.

Хагаралдаж, талцаж хуваагдсан цаг үед бид амьдарч байгаа төдийгүй асар том өөрчлөлтийн хөдөлгөөн дунд мөн амьдарч байна. Түүхийн ямар ч цаг үед байгаагүй тийм их хэмжээгээр хүмүүс нүүцгээж байна, харамсалтай нь ихэвчлэн дүрвэж байна, явган алхаж шаардлагатай бол усанд сэлж дүрвэн нүүсээр, дэлхийн хаа сайгүй нүүдэл. Энэ зөвхөн эхлэл нь. Үүний хариуд бид яаж байна, хилээ хаана, хана босгоно, хөөнө, тусгаарлана. Бид харгислал ноёрхсон тийм ертөнцөд амьдарч байна, мөнгөний нэгж ялгааг үгүй хийж, харин хар тамхи ачсан чингэлэгүүд итгэл найдвар болж. Энэ харгислалын нэг хэсэг нь орон зайг хянаж цагдаад зогсохгүй цаг хугацааг хянаж байна. Бидний амьдран буй цаг хугацаа одоо хэмээх хэмжигдэхүүнээс зайлсхийж байна. Зөвхөн саяхан болж өнгөрсөн болон ойрын ирээдүйг л голлон анхаарна. Энэ надад байхгүй. Би үүнийг худалдаж авна.

Харин одоо худалдаад авчихлаа, тэгээд дараагийн нэг ... юм надад хэрэгтэй. Өнө эртний түүх мартагдаж. Ирээдүйд мөн үр дагавар, үйлийн үр гэж алга.

Үүнийг театр өөрчлөхгүй эсвэл өөрчилж чадахгүй гэж олон хүн хэлэх байх. Гэхдээ л театр хаашаа ч алга болохгүй. Учир нь театр бол газар, бүр хоргодох газар ч гэж хэлж болох байх. Хүмүүс цугларч тэр даруй нэгэн бүлэг болон нэгддэг тэр л газар. Бид үргэлж л ингэдэг. Бүх театр хэмжээгээр анх хүмүүсийн нэгдмэл бүлэг үүссэн тэр л хэмжээнийх байдаг. 50-14 мянга хүртэл хүний сэтгэл зүрх. Нүүдэлчдийн цуваанаас эртний афинчуудын гуравны нэгийг хамарч чадсан.

Тэгээд ч театр зөвхөн энэ цаг үед оршин байдаг учир цаг хугацааны энэ аймшигт үзлийг сорьж байна. Энэ цаг үе бол театрын мөнхийн сэдэв байсаар ирсэн. Утга учрыг нь жүжигчин болон үзэгчдийн хамтын нэгдсэн үйлдлээр тодорхойлдог. Зөвхөн энд ч биш, харин одоо. Жүжигчний үйлдэл үгүй бол үзэгчид итгэхгүй. Үзэгчдийн итгэл үгүй бол бүтээл хагас дутуу болно. Бид хамтдаа инээдэг. Бид хамтдаа хөдөлнө. Бид хамт дуу алдаж, хэлэх үггүй болтлоо цочролд ордог. Драмаар дамжуулан яг энэ мөчид бид хамгийн гүн гүнзгий үнэнийг, биднийг зааглаж ялгаж байгаа гэж бодож байсан бидний

дотоод сэтгэл, ухамсар дахь хязгаар зааг ялгаагүй гэдгийг олж мэднэ. Энэ бол бидний хамтдаа хуваалцдаг зүйл.

Тэгээд ч хэн биднийг зогсоож чадахгүй. Орой бүр бид дахин гарч ирдэг. Үдэш болгон жүжигчид, үзэгчид дахин цугларна. Тэр жүжгээ дахин тоглоно. Учир нь зохиолч Жон Бергер, “Театрын мөн чанарын гүнд зан үйлийн дахин давтагдаж эргэн ирэх шинж оршин байдаг” хэмээн хэлсэн байдаг. Тийм ч учраас энэ бол хэний ч өмчилж чадахгүй урлагийн төрөл ба энэ нь бидний ертөнцийг нурааж, биднийг байгаагаар нь ил болгодог юм. Жүжигчид хаана байна, тэнд үзэгчдийн хамт түүхийг амилуулна, хаана ч хэлж ярьж болохгүй түүхийг илчилнэ. Дэлхийн хаана байх нь чухал биш, дуурийн театр, драмын театр, том хотууд, дүрвэгсдийн лагерь, умард ливийн дүрвэгсдийн хуаран гэх мэт хаана ч байсан хамаагүй. Бид хамтдаа цугларч, нэгдсэн түүнийг амилуулдаг.

Хэрэв бид Эпидауруст байсан бол дээш хараад асар том газар нутагт үүнийг хуваалцаж болохыг харж чадах байсан. Бид үргэлж байгалийн нэг хэсэг байх болно, бид энэ гаригаас хаашаа ч зугтан зайлж чадахгүй. Хэрэв бид Глоб театрт байсан бол хувийн асуултууд биднийг булах нь мэдээж. Хэрэв бид 40 мянган жилийн настай тэрхүү лимбийг гартаа барьж байсан бол өнгөрсөн ба одоог салгаж болохгүй ба хүн төрөлхтний хоорондын гинжин холбоог ямар ч дарангуйлагч, зэрлэг балмад этгээдүүд тасалж чадахгүй гэдгийг ухаарч ойлгох байсан.

Орчуулсан Н. Болороо